

СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛЭХ ХҮСЭЛТ (ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ – ХУУЛИЙН ЭТГЭЭД)

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг /ОУИТБС/ хэрэгжүүлэн Монголын Олборлох салбарын ил тод байдлыг бэхжүүлэх төсөл Зээл/Хөнгөлөлттэй зээл/Буцалтгүй тусламжийн дугаар: TF0B8169

Даалгаврын нэр: Цахим тайлагналын систем, түүний өгөгдлийн системчлэлийг сайжруулах замаар албан статистик мэдээллийг сайжруулах

Худалдан авалтын төлөвлөгөөний харгалзах дугаар: CS-2.1.1-3

Монголын ОУИТБС нь Дэлхийн банкны “ОУИТБС-ыг хэрэгжүүлэн Олборлох салбарын ил тод байдлыг бэхжүүлэх” сангаас санхүүжилт хүлээн авч, зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаанд зарцуула.

Дурдсан зөвлөх үйлчилгээг Монголын ОУИТБС-ын цахим тайлагналыг сайжруулах, шинэчлэн хөгжүүлэхэд ашиглана. Үүнд:

- Одоогийн цахим тайлагналын системийг сайжруулан, хөгжүүлэх, “ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем, e-mongolia танилт нэвтрэлтийн систем, цахим татварын систем, уул уурхайн компьютерийн кадастрын систем, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны систем, газар зүйн мэдээллийн системтэй холбон, мэдээлэл бүрэн солилцдог болгох.
- Нийгмийн сүлжээтэй харьцах чадвар бүхий дэшбордыг хөгжүүлэх, холбогдох мэдээллийг нэгтгэдэг болгох.
- ОУИТБС-ын тайлангийн өгөгдөл мэдээллийг нээлттэй мэдээллийн форматад оруулж, Газар зүйн мэдээллийн системтэй нэгтгэх модуль, ЭйПиАй хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх нийт хугацаа 7 сараас хэтрэхгүй бөгөөд 2023 оны 5-р сараас эхлүүлэхээр төлөвлөж байна.

Тус зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг хавсралт нэгд заасан болно.

Монголын ОУИТБС-ын Ажлын алба нь шаардлага хангасан зөвлөх үйлчилгээний компанийг тус үйлчилгээг нийлүүлэх сонирхлоо илэрхийлэхийг урьж байна. Сонирхогч зөвлөх компани нь энэхүү Үйлчилгээг нийлүүлэхэд шаардлагатай ур чадвар, туршлагатай гэдгээ нотолсон мэдээллийг ирүүлнэ үү. Худалдан авалтын арга нь Дэлхийн Банкны худалдан авалтын дүрмийн /ДБХАД/ Зөвлөхийн ур чадварын арга байна.

ДБХАД-ын 7.2-д заасны дагуу үндсэн үйл ажиллагаа, ажилласан жил, холбогдох туршлага, компанийн мэргэжил болон удирдлагын чадавхыг (Ажлын даалгаварт заасан ерөнхий шаардлагууд) үндэслэн энэхүү даалгаварт ажлыг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг үнэлнэ. Үндсэн ажилчдыг үнэлэхгүй. Хууль ёсны эсэх, сонирхлын зөрчилтэй эсэхийг мөн үнэлнэ. (ДБХАД-ийн 3.21-23 Хууль ёсны байдал).

Компанийн ур чадварын үнэлгээнд түүний салбар, толгой компани, хувьцаа эзэмшигч, дэд гүйцэтгэгч (тендерийн саналд орсон, зөвшөөрөгдсөн мэргэжлийн дэд гүйцэтгэгчээс бусад) болон саналд орсноос өөр компанийн ур чадварыг үнэлэхгүй болно. (ДБХАД-6.27).

Сонирхлоо илэрхийлж буй зөвлөхийн анхаарах зүйл бол ДБХАД-ийн гуравдугаар хэсгийн 3.14, 3.16, 3.17 бөгөөд уг заалт нь Дэлхийн банкны сонирхлын зөрчлөөс сэргийлэх бодлогын дагуу баталсан болно.

Зөвлөх нь нэг л санал ирүүлэх бөгөөд санал нь дан ганц компанийнх, эсхүл хамтарсан, түншлэлийнх байж болно. Хэрэв зөвлөх, эсхүл түүний хамтарсан түншлэлийн этгээд нь нэгээс олон санал ирүүлсэн эсвэл өөр саналд оролцсон бол бүх саналыг хүлээн авахгүй хасна. (ДБХАД-3.20).

Зөвлөх нь өөрийн ур чадварыг нэмэгдүүлж, хийх ажлын чанар, үр дүнг сайжруулах бусад компаниудтай хамтарсан түншлэлд орж болох бөгөөд энэ тохиолдолд хамтарсан, эсхүл дэд гүйцэтгэгч гэдгээ маш тодорхой саналдаа дурдах ёстой. Хамтарсан, түншилсэн тохиолдолд хэрэв сонгогдвол гэрээг бүхэлд нь хамтдаа хариуцна.

Зөвлөхийг Худалдан авах ажиллагааны дүрэмд тодорхойлсон суурь гэрээний зохицуулалт болон тус “Санал ирүүлэх хүсэлт”-д заасны дагуу сонгоно.

Бусад мэдээллийг доорх хаягаар 09:00 - 17:00 цагийн хооронд авч болно.

Сонирхлоо 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 13:00 цагаас өмнө ОҮИТБС-ын Ажлын албанд биеэр, шуудангаар, цахим шуудангийн аль нэгээр албан бичгээр ирүүлнэ үү.

Монголын ОҮИТБС-ын Ажлын алба

Мэдээллийн технологийн зөвлөх С.Болор-Эрдэнэ; Зохицуулагч Ш.Цолмон;

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 26, Сүхбаатарын гудамж 8-5, Пийс Бьюлдинг 205 тоот өрөө

Утас: +976-70110525

Цахим шуудан: admin@eitimongolia.mn; secretariat@eitimongolia.mn

Хавсралт 1 Ажлын даалгавар


Цахим тайлагналын систем, түүний өгөгдлийн системчлэлийг сайжруулах замаар албан статистик мэдээллийг сайжруулах зөвлөх үйлчилгээ (CS-2.1.1-3)

1. Танилцуулга

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) нь байгалийн баялгаас олсон орлогын нээлттэй байдал, удирдлагыг хариуцлагатай болгох чиглэлээр хамтран ажилладаг Засгийн газар, компаниуд, иргэний нийгмийн эвсэл юм. Олборлох салбарын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Их Британийн ерөнхий сайд асан Тони Блейр 2002 онд Өмнөд Африкийн бүгд найрамдах улсын Иоханэсбург хотноо хуралдсан Дэлхийн дээд хэмжээний уулзалт дээр ОУИТБС-ыг зарласан билээ. Одоо эрдсийн баялагтай дэлхийн 56 орон ОУИТБС-ын талаар амлалт аван хэрэгжүүлж байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.eiti.org хуудсанд зочилж мэдээлэл авна уу.

ОУИТБС-ын цахим тайлагналын системийн талаар

Монголын ОУИТБС-ын веб суурьтай цахим тайлагналын системийг 2015 онд ЕСБХБ-ны санхүүжилтээр Адам Смит олон улсын байгууллага, Интерактив ХХК-тай хамтран хөгжүүлж ашиглалтад оруулсан бөгөөд уг системээр компани, төрийн байгууллагууд 30 гаруй төрлийн мэдээллийг жил бүр тайлагнадаг. ОУИТБС-ын стандартын дагуу уг системийг 2020 онд тайлагналын нэмэлт маягт оруулан хөгжүүлсэн бөгөөд 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр серверийн программ хангамжийг шинэчлэн хөгжүүлээд байна.




Зураг 1. Цахим тайлангийн систем - Оролцогч талууд

Зорилт

Дараах шалтгааны улмаас системийн программ хангамжийг засварлах, шинэчлэх, шинэ модулийг хөгжүүлэх, одоо байгаа зарим модулийг шинэчлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Интерактив компанитай үйлчилгээний гэрээ байхгүй.
- Засвар үйлчилгээний ажлыг удаан хугацаагаар хийгээгүй.
- Тайлагналын маягыг шинэчлэх явцад олон тооны асуудал гарч, тэдгээрийг шийдвэрлэх шаардлага үүссэн.
- Зарим модулийн эх кодын технологи нь хуучирч, сервер талдаа программ хангамжийг сайжруулаагүй болон ажиллах системийг шинэчлээгүй байна. Жиш: Судалгаа, анализын хэсэг, санал авах хэсэг.
- Өгөгдөл мэдээллийг нээлттэй өгөгдлийн форматруу экспортлох модуль, нийгмийн сүлжээтэй ажиллах дэшборд, 3-дагч талын аппликейшн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах холболтын модулиудыг хөгжүүлэх шаардлагатай байна.


System main modules structure



Зураг 2. Цахим тайлангийн систем – Одоогийн нөхцөл байдал

2. Үйлчилгээний хамрах хүрээ

Дээр дурдсанчлан энэ төслийн дагуу шаардлагатай шинэчлэлт, алдааг засах, модулийн шинэ дизайн, хуучирсан модулийг дахин боловсруулах, төлөвлөсөн шинэ модулийн хөгжүүлэлт хийгдэнэ. Үйлчилгээ нь долоон төрлийн үйл ажиллагааг хамарна.



Зураг 3. Төлөвлөгөөний бүтцийг шинэчлэх

Энэ баримт бичгийн Зураг 3-т ногооноор тэмдэглэсэн буюу 1). Үндсэн тайлангийн системийн шаардлагатай сайжруулалтууд; 2). Төрийн байгууллагуудтай шаардлагатай мэдээллүүд солилцох API модуль; 3). Гуравдагч талаас програм хангамжаар цахим тайлагналын системд холбогдож, мэдээлэл солилцох API модуль; 4). Системээс гарах боломжит өгөгдлүүдийг нээлттэй өгөгдлийн форматаар экспорт хийх модуль; 6). Судалгаа шинжилгээ, анализын модуль; 7). Нийгмийн сүлжээнд мэдээлэл түгээхээр зориулсан модуль; 10). Үндсэн өгөгдлийн сан гэсэн модулиудын хөгжүүлэлтийг хийхэд шаардлагатай мэдээллүүдийг бэлтгэсэн болно.

2.1. Үйл ажиллагаа

2.1.1. Шинэчлэх, алдаануудыг засах, UI/UX-ийг сайжруулах

- Хөгжүүлэлтийн ажил эхлэхээс өмнө оролцогч талуудтай хамтран, хийх ажлын хуваарь, дизайныг боловсруулах
- Цахим тайлагналын системд шаардагдаж буй модулийг шинэчлэн, хөгжүүлэх
- Одоогийн алдаануудыг засах.

2.1.2. Төрийн байгууллагуудын цахим системтэй өгөгдөл солилцох API модулийг хөгжүүлэх

Төрийн байгууллагуудын шаардлагатай системтэй тодорхой API-аар холбох. Жишээ нь: АМГТГ-ын системрүү холбогдон автоматаар тусгай зөвшөөрлийн мэдээллийг татах, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны системтэй холбогдох, мэдээлэл солилцох, Газар зүйн мэдээллийн системээс мэдээлэл авч, цахим тайлагналын систем дээр газрын зургаар үзүүлэх гэх мэт үйл ажиллагаа орно.

2.1.3. Гуравдагчдагч талын эпликейшн ашиглах API модулийг хөгжүүлэх

API үйлчилгээг ашиглан гуравдагч талын системтэй холбогдох, бүх мэдээллийг цахим тайлагналын систем дээр маягтын дагуу татах, цуглуулах ажлыг энэ модуль хэрэгжүүлнэ.

2.1.4. Байгаа өгөгдлөө нээлттэй өгөгдлийн форматруу экспортлох модуль

Цахим тайлангийн системд цуглуулсан бүх өгөгдлийг загвар, маягт бүрийн дагуу экспортлохоос гадна нээлттэй мэдээллийн форматаар боломжтой шүүлтүүрээр шүүсэн өгөгдлийг экспортлоно.

2.1.5. Судалгаа анализын модуль

Судалгааны байгууллага, судлаачид болон ОУИТБС-ын мэдээллийг сонирхож буй бусад хүмүүст зориулсан хамгийн өргөн хүрээний шүүлтүүр (динамик шүүлтүүр) бүхий судалгаа, шинжилгээний шинэ модулийг боловсруулна.

2.1.6. Нийгмийн сүлжээнд ээлтэй инфографикийн модуль

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр инфографик түгээх, гар утас, планшетаас үзэх боломжтой, олон нийтийн сонирхлыг татсан 10 орчим төрлийн мэдээлэл, инфографик бэлтгэн харуулах шинэ модуль боловсруулна. Огноо, байршил гэх мэт хэд хэдэн тодорхой төрлийн шүүлтүүртэй байх.

2.1.7. Өгөгдлийн баазын өөрчлөлт

Дээрх 6 үйл ажиллагаатай нийцсэн өгөгдлийн баазын өөрчлөлт, тэдгээрийг оновчтой болгох үйл ажиллагааг хөгжүүлэх, тохируулга хийнэ. Ялангуяа, тайлан, инфографикийн өмнө нь тооцоолсон мэдээллийг харуулах үйл ажиллагааг автоматаар гаргана.

3. Гаргах бүтээгдэхүүн болон тайлагнал

3.1 Гаргах бүтээгдэхүүн

Зөвлөх нь гэрээнд гарын үсэг зурснаас хойш 7 сарын дотор дараах ажлуудыг гүйцэтгэнэ.

3.1.1. Программ хангамж боловсруулах, хэрэгжүүлэх

2.1-д заасан үйл ажиллагааны шаардлагын дагуу программ хангамжийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх.

3.1.2. Хэрэглэгчийн гарын авлага

Хөгжүүлсний дараа шинээр боловсруулсан модулиудын хэрэглэгчийн гарын авлагыг бэлтгэх.

3.1.3. Одоо байгаа хэрэглэгчийн гарын авлагыг шинэчлэх

Хуучин гарын авлагыг шинэчлэн, хийгдсэн шинэчлэлийн дагуу шинэ гарын авлага гаргах.

3.1.4. Вэб үйлчилгээний баримт бичиг

Вэб үйлчилгээний баримт бичгийг бэлтгэх.

3.1.5. UX/UI-д зориулсан баримт бичиг

UX/UI дизайны баримт бичгийг бэлтгэх.

3.1.6. Эх кодууд

Эх кодын шинэчлэлтийг ОУИТБС-ын ажлын албанд хүлээлгэж өгнө.

3.2 Тайлагнал

3.2.1 Эхлэлийн тайлан

Гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор системийн шинжилгээний төсөл болон ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан ОУИТБС-ын Ажлын албанд танилцуулна.

3.2.2 Явц эсвэл завсрын тайлан

Зөвлөх нь явцын тайланг сар бүр ОУИТБС-ын Ажлын албанд тайлагнана. Завсрын тайланг гэрээ байгуулснаас хойш 5 сарын дараа ОУИТБС-ын Ажлын албанд танилцуулна. Завсрын тайланг танилцуулахад 2.1.1, 2.1.2, 2.1.3 дугаар үйл ажиллагааг ОУИТБС-ын Ажлын алба баталгаажуулсан байна.

3.2.3 Эцсийн тайлан

Эцсийн тайланг программ хангамжийг нэвтрүүлсний дараа ОУИТБС-ын Ажлын албанд танилцуулна. Эцсийн тайланг танилцуулахад 2.1.4, 2.1.5, 2.1.6, 2.1.7 үйл ажиллагааг ОУИТБС-ын Ажлын алба баталгаажуулсан байна.

4. Үйлчилгээний хугацаа, тооцоолол

Хэрэгжүүлэх нийт хугацаа 7 сараас хэтрэхгүй бөгөөд 2023 оны 5-р сараас эхлүүлэхээр төлөвлөж байна.

Үе шат	Хугацаа	Төлбөр /Нийт үнийн дүнгийн хувь/
Гэрээ байгуулан, ОУИТБС-ын Ажлын албатай зөвшилцөж ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргана.	-	30%
Явцын тайлан. Системийн нарийвчилсан шинжилгээ бүрэлдэхүүн хэсгүүдийн дизайн, өгөгдлийн сангийн бүтэц, програмын функционал дизайн ба системийн интерфэйсийг оруулсан байна. Түүнчлэн системийг ажиллуулахад шаардлагатай нэмэлт програм хангамж, тоног төхөөрөмжийн шаардлагыг боловсруулсан байна. Системийн бизнес прецессийн зураглалыг BPMN болон албан ёсны стандартчилагдсан процессын хэл, форматаар ирүүлнэ. (цахим файл хэлбэрээр)	Гэрээ байгуулснаас хойш 3 сарын дотор	30%
Урьдчилсан тестийн хувилбар тайлан. Үүнд: Системийн хөгжүүлэлтийн тайлан байна. Мөн системийг ажиллуулахад техникийн орчинг тохируулж бэлтгэсэн байна.	Гэрээ байгуулснаас хойш 5 сарын дотор	20%
Эцсийн тайлан. Үүнд: Хэрэгжүүлэгч байгууллагаар батлуулсан системийн загвар, эх код, өгөгдлийн толь, өгөгдлийн урсгалын диаграмм, програмын шаардлага, тестийн тайлангийн нэгтгэл, сургалтын тайлангийн дүгнэлт, хэрэглэгчийн гарын авлага гм баримт бичгүүд орно. Цахим тайлагналын 1.5 хувилбарыг нэвтрүүлсэн байна.	Гэрээ байгуулснаас хойш 7 сарын дотор	20%

5. Ерөнхий шаардлага

- Зөвлөх нь татварын өргүй байх. Үүнийг Татварын Ерөнхий Газрын тодорхойлолтоор баталгаажуулна.
- Зөвлөх нь нийгмийн даатгалын өргүй байх. Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын тодорхойлолтоор баталгаажуулна.
- Зөвлөх нь сүүлийн 3 жилийн хугацаанд Эрүүгийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийг болон худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчөөгүй байх. Үүнийг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын тодорхойлолтоор баталгаажуулна.
- Зөвлөх нь сүүлийн 5 жилд вебд суурилсан системүүдийг амжилттай хэрэгжүүлсэн байх. Төсөл хэрэгжүүлсэн гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн актаар баталгаажуулна.
- Зөвлөх нь цахим тайлангийн системтэй дүйцэхүйц системийн аналитик шийдэл, мэдээллийн сангийн инженерчлэл, API-ийг нь хөгжүүлсэн талаар туршлагаа нотолно.
- Зөвлөх нь техникийн болон техникийн бус цогц асуудлыг шийдвэрлэж байсан туршлагаа нотлох.
- Зөвлөх нь цахим тайлагналын системийг төслийн төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах чадвартай, хүний нөөцтэй бол илүү үнэлгээ авна.

Ерөнхий шаардлагад нийцээгүй зөвлөхийн саналыг үнэлгээнд оруулахгүй хасна.

6. Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо:

1. Сүүлийн таван жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн төслүүдийн (хэрэгжүүлж байгаа) туршлага. Төсөл хэрэгжүүлсэн байгууллагын албан тодорхойлолт, гэрээний хуулбар, ажил хүлээлцсэн актаар баталгаажна. /Нийт 70 оноо/
 - 1.1 Ижил төстэй систем хөгжүүлсэн туршлага /40 оноо/
 - Ижил төстэй ажил амжилттай хэрэгжүүлсэн тоо 10 буюу түүнээс дээш: 40 оноо
 - Ижил төстэй ажил амжилттай хэрэгжүүлсэн тоо 7-9: 28-36 оноо
 - Ижил төстэй ажил амжилттай хэрэгжүүлсэн тоо 4-6: 16-24 оноо
 - Ижил төстэй ажил амжилттай хэрэгжүүлсэн тоо 1-3: 4-12 оноо
 - Ижил төстэй ажил амжилттай хэрэгжүүлсэн тоо 0: 0 оноо
 - 1.2 Цахим тайлангийн системтэй дүйцэхүйц, 2000 буюу түүнээс дээш хэрэглэгчтэй, Back-end, front-end, болон өгөгдлийн сан, тайлан зэрэг цогц бүтэц бүхий, одоо ашиглагдаж байгаа системүүд хамаарна /30 оноо/
 - Томоохон хөгжүүлсэн системийн тоо 4 буюу түүнээс дээш: 30 оноо
 - Томоохон хөгжүүлсэн системийн тоо 3: 20 оноо
 - Томоохон хөгжүүлсэн системийн тоо 2: 10 оноо
 - Томоохон хөгжүүлсэн системийн тоо 1: 5 оноо
 - Томоохон хөгжүүлсэн системийн тоо 0: 0 оноо
2. Зөвлөхийн ерөнхий туршлага. Програм хангамж хөгжүүлэлтийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулсан жилийн тоо. /Нийт 20 оноо/
 - 2.1 Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан жилийн тоо 5 буюу түүнээс дээш: 20 оноо
 - 2.2 Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан жилийн тоо 4: 16 оноо
 - 2.3 Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан жилийн тоо 3: 12 оноо
 - 2.4 Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан жилийн тоо 2: 8 оноо
 - 2.5 Үйл ажиллагаа идэвхтэй явуулсан жилийн тоо 1 буюу түүнээс бага: 4 оноо
3. Ажиллах хүчний чадамж (Үүнд хувь хүний чадвар, CV үнэлгээнд хамаарахгүй) Зөвхөн үндсэн ажилтнуудыг мэдээлэл хамаарна. /Нийт 10 оноо/
 - 3.1. Үйл ажиллагааны менежментийн чадамж. /3 оноо/

- Үндсэн үйл ажиллагааны менежментийн ажилтнуудын тоо 3 буюу түүнээс дээш: 3 оноо
 - Үндсэн үйл ажиллагааны менежментийн ажилтнуудын тоо 2: 2 оноо
 - Үндсэн үйл ажиллагааны менежментийн ажилтнуудын тоо 1: 1 оноо
- 3.2. Програм хангамжийн инженерүүдийн ажиллах хүчний чадамж. /4 оноо/
- Програм хангамжийн инженерүүдийн тоо 5 буюу түүнээс дээш: 4 оноо
 - Програм хангамжийн инженерүүдийн тоо 4: 3 оноо
 - Програм хангамжийн инженерүүдийн тоо 3: 2 оноо
 - Програм хангамжийн инженерүүдийн тоо 2: 1 оноо
 - Програм хангамжийн инженерүүдийн тоо 1: 0 оноо
- 3.3. Систем админ инженерүүдийн чадамж /3 оноо/
- Систем админ инженерүүдийн тоо 3 буюу түүнээс дээш: 3 оноо
 - Систем админ инженерүүдийн тоо 2: 2 оноо
 - Систем админ инженерүүдийн тоо 1: 1 оноо
 - Систем админ инженерүүдийн тоо 0: 0 оноо

Зөвлөхийн авбал зохих доод оноо 80 бөгөөд үүнээс доош оноо авсан зөвлөхийн саналаас татгалзана.

--o00o--